

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/340 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл технологийн газрын дарга Л.Мөнхтулга даргаар ахлуулсан ЭМЯ, ЭМХТ-ийн ЭТТАлбаны мэргэжилтнүүдээ бүрдсэн ажлын хэсэг 5 багт хуваагдан, 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2017 оны 10 дугаар сарын 21-ны өдөр хүртэл ЭМЯ-ны харьяа Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээ хийлээ.

Үнэлгээний зорилго:

Төв эмнэлэг, тусгай мэргэжилийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, тулгамдсан асуудлыг тодорхойлох, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээтэй холбоотой тооцоо, судалгаа гаргах.

Үнэлгээний зорилт:

1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах
2. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага тодорхойлох
3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн илүүдэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдтэй газар дээр нь танилцаж, шилжүүлэх арга хэмжээ авах
4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эвдрэл гэмтэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа гаргах
5. Засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, төсвийг гаргаж, нэгдсэн байдлаар шийдвэрлэх арга хэмжээ авах
6. Гадны хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн болон хийгдэх төсөл хөтөлбөрийн явц
7. Актлах болон ашиглалтаас гаргах тоног төхөөрөмжтэй танилцах
8. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчдын хангалт, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, МАТЕРИАЛ

Үнэлгээний аргачлал: Үнэлгээнд чанарын болон тоон судалгааны аргыг ашигласан.

Мэдээлэл цуглуулалт: Баримтын болон асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан.

Баримтын аргаар дараах мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийлээ:

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага тодорхойлсон судалгаа
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, актлах тоног төхөөрөмжүүдээ тодорхойлсон судалгаа
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэр

Мөн ЭМЯ-ны сайдын баталсан удирдамжийн дагуу тусгайлан боловсруулсан загвар асуулгыг ашиглан, өөрсдөөр нь асуумжийг бөглүүлж, ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Хамрах хүрээ: Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд

Сонгосон бүлэг: Төв эмнэлэг тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилчид, холбогдох бусад мэргэжилтнүүд

Мэдээлэл боловсруулалт: Баримтын болон ярилцлагаар цуглуулсан мэдээлэлд агуулгын дүн шинжилгээ хийж, тоон мэдээлэлд энгийн статистик шинжилгээ хийлээ.

Ажиллах хүчин: Эрүүл мэндийн яамны санхүүгийн мэргэжилтнүүд, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүд болон Төв эмнэлэг тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүд гүйцэтгэлээ. Баг тус бүрийн тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтнүүд гүйцэтгэж, Б.Сансармаа дүн шинжилгээ хийн, үр дүнгийн тайлан бичлээ.

Мэдээлэл түгээх: Үнэлгээний тайланг ЭМЯ-ны бодлого боловсруулагч, эрүүл мэндийн байгууллага, хэрэглэгчдэд түгээнэ.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах

Багууд ажлын хэсгийн тушаалын дагуу хуваарилагдсан үндэсний төвүүдийн удирдлага, инженер техникийн ажилтантай уулзаж ярилцан, эмнэлгийн барилга байгууламж, цахилгаан систем, эмнэлгийн хийн систем, агааржуулалт, газардуулгын системтэй танилцаж тулгамдаж буй асуудлыг судаллаа.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийн талаарх ерөнхий мэдээллийг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Барилга, дэд бүтэц

№	Эмнэлгийн нэр	Нэгдсэн систем					Барилга байгууламж нөхцөл байдал тулгамдсан асуудал
		Байгууламжийн тоо	Цахилгааны нэмэлт үүсвэр	Газардуулга	Агааржуулалт	Эмнэлгийн хийн хангамж	
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	2	Байгаа	Тийм	Тийм	Тийм Хэсэгчилсэн	
2	Хавдар судлалын үндэсний төв	1	Байгаа	Тийм	Тийм	Тийм Хэсэгчилсэн	Өргөтгөлийн барилга ашиглалтад ороогүй
3	Эмгэг судлалын үндэсний төв	-	Байгаа	Байхгүй	Тийм	Шаардлагагүй	Өөрийн гэсэн байргүй
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	5	Байгаа	Тийм	Тийм	Тийм	
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	5	Байгаа	Байхгүй	Тийм	байхгүй	
6	Геронтологийн үндэсний төв	-	Байгаа	Тийм	Тийм	Тийм	Өөрийн гэсэн байргүй. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хэзээ ч нурж болзошгүй барилгатай тул энэхүү барилгадаа үйл ажиллагаагаа явуулахыг хориглосон 3 удаагийн дүгнэлт ирсэн
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	5	Байгаа	Тийм	Тийм	Тийм	
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	6	Байгаа	Тийм	Тийм	Тийм	
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	5	Байгаа	Тийм	Байхгүй	Шаардлагагүй	Улсын нөөцийн фондны агуулхын байр чанарын шаардлага хангадаггүй, төмөр учир халуунд хэт халуун хүйтэнд хэт хөрж хадгалж байгаа зүйлсийн чанар алдагдуулах аюултай.

10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	28	Байгаа	Тийм	Тийм	Тийм	1986 онд ашиглалтад орсон 2 барилга хөрсний суулт, цэвдгээс болж байгууллагын хананд ан цав гараад байна. Мөн өвчтөн зөөвөрлөх зориулалттай хавцаны эвдрэлээс шалтгаалан барилгын хана гаднаас чийг орж эвдрэл үүссэн 4 барилга байна.
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	3	Байгаа	Тийм	Тийм	Тийм	А байрны дээвэр муудаж борооны ус гоожиж, цан цохидог.
12	Хүүхдийн төв сувилал	1	Байгаа	Тийм	Тийм	Тийм	Сантехникийн шугам хоолойг шинэчлэх шаардлагатай. Барилгын хэсэгчлэсэн засвар хийлгэх шаардлагатай байна
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	1	Байгаа	Тийм	Тийм	Тийм Хүчилтөрөгчийн үйлдвэртэй	-
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	2	Байгаа	Тийм	Тийм	Шаардлагагүй	-
15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	3	байхгүй	Тийм	байхгүй	Шаардлагагүй	-

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн барилга байгууламж, дэд бүтцийн хувьд өөрийн гэсэн байргүй 2 (Эмгэг судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв) төв байна. Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөлийн байр ашиглалтад ороогүй бөгөөд ашиглагдаж буй байр нь ашиглах нөхцөл муудсан 5 эрүүл мэндийн байгууллага байна. Жишээлбэл: Халдварт өвчин судлалын үндэсний төв - 1986 онд ашиглалтад орсон 2 барилга хөрсний суулт, цэвдгээс болж байгууллагын хананд ан цав гараад байна. Мөн өвчтөн зөөвөрлөх зориулалттай хавцаны эвдрэлээс шалтгаалан барилгын хана гаднаас чийг орж эвдрэл үүссэн 4 барилга байна. Хүүхдийн төв сувилал - Сантехникийн шугам хоолойг шинэчлэх шаардлагатай. Барилгын хэсэгчлэсэн засвар хийлгэх шаардлагатай байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төв - А байрны дээвэр муудаж борооны ус гоожиж, цан цохидог.

Геронтологийн үндэсний төв - Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хэзээ ч нурж болзошгүй барилгатай тул энэхүү барилгадаа үйл ажиллагаагаа явуулахыг хориглосон 3 удаагийн дүгнэлт ирсэн.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв - Улсын нөөцийн фондны агуулхын байр чанарын шаардлага хангадаггүй, төмөр учир халуунд хэт халуун хүйтэнд хэт хөрж хадгалж байгаа зүйлсийн чанар алдагдуулах аюултай.

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт **314** нэр төрлийн **871** ширхэг, **46,9 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалтын хувь **91%**-тай байна. 2016 онд Австри улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлийн хүрээнд 49 нэр төрлийн 136 ширхэг, **17,2** тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Улсын нэгдүгээр төв эмнэлэгт **371** нэр төрлийн **943** ширхэг, **23,5 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **98,9%**-тай байна. 2016 онд Австри улсын

Засгийн газрын хөнгөлттэй зээлийн хүрээнд 13 нэр төрлийн 18 ширхэг, **17,2 тэрбум** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Эмгэг судлалын үндэсний төвд **8** нэр төрлийн **25** ширхэг, **193,7 сая** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **100%**-тай байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлэгт **126** нэр төрлийн **327** ширхэг, **4,8 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **96,6%**-тай байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд **84** нэр төрлийн **174** ширхэг, **1,6 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт хувь **100%**-тай байна.

Геронтологийн үндэсний төвд **19** нэр төрлийн **26** ширхэг, **322,9 сая** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **73%**-тай байна.

Улсын гуравдугаар төв эмнэлэгт **353** нэр төрлийн **1478** ширхэг, **57,8 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **90,3%**-тай байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **500** нэр төрлийн **2424** ширхэг, **31,8 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт хувь **95,1%**-тай байна. 2016 онд Австри улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлийн хүрээнд **101** нэр төрлийн **293** ширхэг, **17,2** тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Халдварт өвчин судлалын үндэсний төвд **300** нэр төрлийн **684** ширхэг, **2,0 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **83,3%**-тай байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төвд **52** нэр төрлийн **110** ширхэг, **933,7 сая** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **79%**-тай байна.

Хүүхдийн төв сувилалд **43** нэр төрлийн **124** ширхэг, **202,3 сая** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **83%**-тай байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвд **83** нэр төрлийн **309** ширхэг, **9,5 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалтын **98%**-тай байна. 2015-2016 онуудад Францын төслөөр 26 нэр төрлийн 170 гаран ширхэг, **3 сая еврогийн** үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн нь тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг эрс сайжирсан байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвд **309** нэр төрлийн **879** ширхэг, **7,5 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Тоног төхөөрөмж ашиглалт **95%**-тай байна. 2015-2016 онуудад Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр - V төслийн хүрээнд **150** нэр төрлийн **646** ширхэг, **5,3 тэрбум** эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн нь тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг эрс сайжруулсан байна.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Биотехнологи инновацийн алба, Нийгмийн эрүүл мэндийн лавлагаа лаборатори болох Хоол судлал шим тэжээлийн лаборатори, Хор судлалын лаборатори гэсэн 3 үндсэн хэсэгтэй үйл ажиллагаа явуулж байна. Тус төвд өнөөдрийн байдлаар **96** нэр төрлийн **97** ширхэг, **1,1 тэрбум** төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна.


Нийт төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд **2790** нэр төрлийн (давхардсан тоогоор), **8640** ширхэг, **177,4 тэрбум** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын дундаж **90,02%**-тай байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын мэдээллийг Хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 2. Тоног төхөөрөмжийн ашиглалт

№	Эмнэлгийн нэр	Тоног төхөөрөмжийн		Үнийн дүн /сая.төг/	Ашиглалт /хувь/
		Нэр төрөл	Тоо ширхэг		
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	314	871	46,991.0	91
2	Хавдар судлалын үндэсний төв	371	943	6,352.0	98.9
3	Эмгэг судлалын үндэсний төв	8	25	193.7	100
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	126	327	4,897.7	96.6

5	Сэтгэцийн эрүүлмэндийн үндэсний төв	84	174	1,688.2	100
6	Геронтологийн үндэсний төв	19	26	322.9	73
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	353	1478	57,824.5	90.3
8	Эх хүүхдийн эрүүлмэндийн үндэсний төв	500	2424	31,899.2	95.1
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	132	169	1,269.2	97.1
10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	300	684	6,686.0	83.3
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	52	110	933.7	79
12	Хүүхдийн төв сувилал	43	124	202.3	83
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	83	309	9,500.0	98
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	309	879	7,590.8	90
15	Нийгмийн эрүүлмэндийн үндэсний төв	96	97	1,087.7	75
НИЙТ		2,790.0	8,640.0	177,438.8	
ДУНДАЖ					90.02



Дүрслэл 1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангамж, ашиглалт

Тоног төхөөрөмжийн ашиглалт, хөрөнгө оруулалттай холбоотой санал хүсэлтүүд:

- ✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын төсөв байгууллагын төсөвт суудаггүй.
- ✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сэлбэг хэрэгслийн төсөв огт хүрэлцдэггүй маш багаар бусад зардалтай хамт ирүүлдэг.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг:

- ✓ ЭМХТ-өөс хийгддэг шалгалт тохируулга, баталгаажуулалтанд дараах асуудлууд тулгараад байна. 2017 оны төлөвлөгөөт шалгалт тохируулга баталгаажуулалтад тэнцээгүй өвчтөний хяналтын мониторуудыг ханган нийлүүлсэн Медимпекс интернэйшнл ХХК, Мед Жей ХХК, Бэйссан ХХК нарт засвар тохируулга хийлгэхээр хандан албан хүсэлт илгээсэн боловч өнөөг хүртэл албан ёсны хариу ирүүлж арга хэмжээ аваагүй байна.

Улсын гуравдугаар төв эмнэлэг:

- ✓ Дурангийн оношилгооны тасагт 1 ходоодны дуран ажиллаж байгаа боловч засвар хийх шаардлагатай гэсэн инженерийн дүгнэлт гарсан цаашдаа дурангийн норм төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон

тул үйлчлүүлэгчдэд өгдөг амбулаторийн үзлэгийн цагийг бүр мөсөн зогсоож зөвхөн яаралтай тусламж, тасгуудаас ирж байгаа дурангийн шинжилгээ шаардлагатай үйлчлүүлэгчдэд үйлчилж байна.

Геронтологийн үндэсний төв:

- ✓ Уг төвд лаборатори огт байхгүй тул оношилгоо, эмчилгээнд хүндрэл учирдаг. Уг чиглэлээр ажиллах эмч мэргэжилтнүүд нь бэлтгэгдсэн байрны хувьд гаргах боломжтой боловч лабораторийн тоног төхөөрөмжүүд нь байхгүй байна.
- ✓ Лабораторийн урвалжийн төсөв хүрэлцдэггүй.
- ✓ Нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн төсвийг шийдвэрлэж өгөх жишээ нь: Давхар нэрэлтэй ус нэрэгч
- ✓ Автомашин хэрэгтэй. Хоёр машин шаардлага хангахгүй байгаа бөгөөд хөдөө орон нутгаар явах шаардлага маш их гардаг. Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг үндэсний төв бөгөөд ахмад настуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг учраас автомашин хэрэгцээ маш өндөр чухал шаардлагатай.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв:

- ✓ Лабораторийн урвалжийн төсөв хүрэлцдэггүй.
- ✓ 2016 онд хөрөнгө оруулалтаар шинэ микро автобус авсан боловч ЭМС-ын даалгавраар ЭМЯ авсан боловч өнөөдрийг хүртэл ямар нэгэн санхүүгийн бичиг баримт шилжүүлэг хийгдээгүй. Оронд нь суудлын х-тrial загварын машин өгнө гэсэн боловч өдийг хүртэл өгөөгүй байгаа.
- ✓ Эмнэлгийн хийн хангамжийн системийн ханын төгсөвч хийсэн боловч зөвхөн хүчилтөрөгч нь ажиллаж байгаа вакуум болон эмнэлгийн зориулалтын агаарыг ашиглахын тулд нэмэлтээр компрессор тавих шаардлагатай.
- ✓ Хэт авиан оношилгооны аппарат сүлжээнд холбогдох боломжгүй байгааг цаашид уламжлан цахим системд холбох боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төв:

- ✓ Өвчтөний онош тодруулах зорилгоор Компьютер томографийн зураг авах шаардлага их байдаг. Ойролцоох эрүүл мэндийн байгууллагууд дээр очиж компьютер томографийн зураг авахуулах боломжоор хангах шаардлагатай.
- ✓ Агааржуулалтын систем орчин үеийн стандарт шаардлага хангахгүй байна. Халдвартын эмнэлгийн хамгийн чухал зүйл бол агааржуулалтын систем байдаг. Өнөөдөр манай эмнэлгийн лаборатори, мэс засал, сэхээн амьдруулах эрчим эмчилгээ, СК-ийн I, II IV, мэс заслын тасагт агааржуулалтын систем нь огт ажиллагаагүй байдаг.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв:

- ✓ 2012 онд “Өнөд орших мөрөн” ХХК-наас нийлүүлэгдсэн 5 багц тоног төхөөрөмжийн 1 ба 5-р багцууд суурилагдаж, акт үйлдсэн, 2, 3, 4-р багцын тоног төхөөрөмжүүд ирсэн боловч одоог хүртэл бүрэн ашиглалтад ороогүй, зарим тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүй байдаг. Тухайн газартай холбогдох боломжгүй байгаа. Шүүхийн асуудалтай байгаа.
- ✓ Биотехнологи, инновацийн албаны тоног төхөөрөмж ихэнх нь 1980-аад онд үйлдвэрлэгдсэн, шинэчлэлт хийх шаардлагатай, урвалж оношлуурын хангамж муутай.

3.2. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага тодорхойлох

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулахад нийт **23,4 тэрбум** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, шалгалт баталгаажуулалтын зардалд **121,4 сая төгрөг** шаардлагатай байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг Хүснэгт 3.1, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтад хамрагдах тоног төхөөрөмж, шаардагдах төсвийг Хүснэгт 3.2 - д үзүүлэв.

Хүснэгт 3.1 Тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлага

№	Эмнэлгийн нэр	Тоног төхөөрөмжийн		Үнийн дүн /сая.төг/
		Нэр төрөл	Тоо ширхэг	
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	21	45	689.0
2	Хавдар судлалын үндэсний төв	35	366	5,516.3
3	Эмгэг судлалын үндэсний төв	17	35	660.0
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	60	98	7,400.0
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	-	-	-
6	Геронтологийн үндэсний төв	-	21	415.2
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	7	24	
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	14	194	1,991.0
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	27	48	314.5

10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	83	1235	3,776.5
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	44	71	861.7
12	Хүүхдийн төв сувилал	20	40	443.8
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	5	32	618.0
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	7	7	113.5
15	Нийгмийн эрүүлмэндийн үндэсний төв	16	27	669.1
НИЙТ				23,468.6

Хүснэгт 3.2 Шалгалт баталгаажуулалтад хамрагдах тоног төхөөрөмжийн тоо, шаардагдах санхүүжилт

№	Эмнэлгийн нэр	Шалгалт баталгаажуулалтад хамрагдах ЭТТ-ийн тоо		Шаардлагатай санхүүжилт /төгрөг/
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	338		23,961,000.0
2	Хавдар судлалын үндэсний төв	176		9,816,000.0
3	Эмгэг судлалын үндэсний төв	0		-
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	114		8,962,000.0
5	Сэтгэцийн эрүүлмэндийн үндэсний төв	27		1,911,000.0
6	Геронтологийн үндэсний төв	4		275,000.0
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	53		3,775,000.0
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	740		49,984,000.0
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	0		-
10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	176		11,343,000.0
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	4		286,000.0
12	Хүүхдийн төв сувилал	32		1,626,000.0
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	131		9,445,000.0
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	2		102,000.0
15	Нийгмийн эрүүлмэндийн үндэсний төв	0		-
НИЙТ				121,486,000.0

3.3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн илүүдэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжүүдтэй газар дээр нь танилцаж, шилжүүлэх арга хэмжээ авах

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн илүүдэлтэй болон ашиглагдахгүй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, судалгааны дагуу газар дээр нь тухайн илүүдэлтэй байгаа тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, шилжүүлэн ашиглах боломжийг судлан үзлээ. Нийт эмнэлгийн хэмжээнд 6 тоног төхөөрөмж илүүдэлтэй, тэдгээр тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэх боломжтой байна. Бусад эрүүл мэндийн байгууллагуудад илүүдэлтэй тоног төхөөрөмж байхгүй болно.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн илүүдэлтэй тоног төхөөрөмжийн мэдээлийг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт. 4 Илүүдэлтэй тоног төхөөрөмж болон шилжүүлэн ашиглах боломжтой тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Эмнэлгийн нэр	Илүүдэлтэй тоног төхөөрөмж	Цаашид ашиглах боломжтой шилжүүлэх боломжтой тоног төхөөрөмж
---	---------------	----------------------------	--

		Тоо	Нэр төрөл	Тоо /төрөл	Тайлбар
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	1	Зөөврийн рентген	1	-
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	1	Угаалгын автомат машин	1	Төвлөрсөн цэвэр болон бохирын шугаманд холбогдсон байгууллагад ашиглах боломжтой.
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	1	Цусан дахь хийг хэмжих анализатор	1	-
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	3	80л Автоклав Ширээний автоклав Элиза уншигч	3	Өөрийн салбар ЗӨСТөвд шилжүүлэх Шүдний эмнэлэгт шилжүүлэх Клиникийн эмнэлэгт шилжүүлэх
НИЙТ		6		6	

3.4. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эвдрэл гэмтэлтэй байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа гаргах

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эвдрэл гэмтэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэн үзэхэд нийт эмнэлгүүдийн хэмжээнд 105 нэр төрлийн 365 ширхэг тоног төхөөрөмж гэмтэлтэй бөгөөд засварлах шаардлагатай байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн гэмтэлтэй тоног төхөөрөмжийн мэдээллийг Хүснэгт 5-т үзүүлэв.

Хүснэгт 5 Гэмтэлтэй тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Эмнэлгийн нэр	Тоног төхөөрөмжийн		Шаардагдах төсөв /сая. төг/
		Нэр төрөл	Тоо ширхэг	
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	33	78	246.4
2	Хавдар судлалын үндэсний төв	-	10	628.0
3	Эмгэг судлалын үндэсний төв	-	-	38.1
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	4	11	
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	-	-	-
6	Геронтологийн үндэсний төв	-	-	-
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	7	7	242.7
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв		118	368.0
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	7	10	53.6
10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	28	104	102.0
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	1	1	22.5
12	Хүүхдийн төв сувилал	3	4	2.3
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	-	-	-
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	7	7	94.2
15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	15	15	21.0
НИЙТ		105	365	1,818.8

Зорилт 5. Засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгсэл, төсвийг гаргаж, нэгдсэн байдлаар шийдвэрлэх арга хэмжээ авах

Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд **7,0 тэрбум** төгрөг шаардлагатай байна. Үүнийг ангилж үзвэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд **1,8 тэрбум** төгрөг, хугацаат сэлбэг хэрэгслийн зардалд **2,1 тэрбум** төгрөг, өндөр өртөгт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд **3,1 тэрбум** төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.


Жич: Өндөр өртөгт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд MRI, CT, ангиографийн аппаратны үйлдвэрлэгчийн баталгаат засварын алтан, мөнгөн гэрээг хамааруулав.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгслийн төсвийн тооцоо Хүснэгт 6-д үзүүлэв.

Хүснэгт.6 Засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг хэрэгслийн төсвийн тооцоо

№	Эмнэлгийн нэр	Засвар үйлчилгээ	Хугацаат сэлбэг хэрэгсэл	Өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	246.4	1,010.0	1,033.0
2	Хавдар судлалын үндэсний төв	628.0	-	
3	Эмгэг судлалын үндэсний төв	38.1	-	-
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг		74.0	69.7
5	Сэтгэцийн эрүүлмэндийн үндэсний төв	-	-	-
6	Геронтологийн үндэсний төв	-	-	-
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	242.7	584.2	600.0
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	368.0	343.2	689.6
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	53.6	20.0	-
10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	102.0	-	63.5
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	22.5	19.6	40.5
12	Хүүхдийн төв сувилал	2.3	-	-
13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	-	40.3	630.0
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	94.2	55.9	-
15	Нийгмийн эрүүлмэндийн үндэсний төв	21.0	-	-
НИЙТ		1,818.80	2,147.2	3,126.3
БҮГД				7,092.35

Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай санхүүжилт



Дүрслэл 2. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний санхүүжилт ийн хангамж, ашиглалт

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд шаардагдах санхүүжилтийг нэгтгэж үзвэл нийт **184,531.7** сая төгрөг шаардлагатай байна.

3.6. Гадны хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн болон хийгдэх төсөл хөтөлбөрийн явц

ЭМЯ-ны харьяа 6 эрүүл мэндийн байгууллагуудад гадаадын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд 2016-2017 онуудад **69,9 тэрбум** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаатай байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн мэдээллийг Хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт.7 Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн мэдээлэл (сая.төгрөг)

№	Эмнэлгийн нэр	Австри улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл	Францын улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл	Японы улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламж	АХБ-ны ЭМСХХ-V Төсөл
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	17,295.0			
2	Хавдар судлалын үндэсний төв	17,295.0			
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг				
4	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	17,295.0		5,252.0	
5	Гэмтэл согог судлалын үндэсний төв		7,500.0		
6	Цус сэлбэлт судлалын үндэсний төв				5,300.0
НИЙТ		51,885.0	7,500.0	5,252.0	5,300.0
		БҮГД			69,937.0

3.7. Актлах болон ашиглалтаас гаргах тоног төхөөрөмжтэй танилцах

ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын актлах болон ашиглалтаас гаргах тоног төхөөрөмжтэй танилцлаа. Нийт 15 байгууллагаас 8 байгууллага 514 ширхэг **1,493.1 сая** төгрөгийн тоног төхөөрөмж актлаж,

ашиглалтаас гаргахаар холбогдох байгууллагад хүсэлтээ өгсөн байна. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн актлах тоног төхөөрөмжийн мэдээллийг Хүснэгт 8-д үзүүлэв.

Хүснэгт 8. Актлах тоног төхөөрөмжийн мэдээлэл

№	Эмнэлгийн нэр	Тоног төхөөрөмжийн тоо	Нийт үнийн дүн
1	Эмгэг судлалын үндэсний төв	65	156,956,624.0
2	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	115	51,372,549.0
3	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	3	20,000,000.0
4	Халдварт өвчин судлалын үндэсний төв	15	86,565,120.0
5	Арьсны өвчин судлалын үндэсний төв	23	107,693,350.0
6	Хүүхдийн төв сувилал	2	6,846,000.0
7	Гэмтэл согог судлалын үндэсний төв	289	1,061,230,309.5
8	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	2	2,500,000.0
НИЙТ		514	1,493,163,952.5

3.8. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчдын хангалт, сургалтын хэргцээ шаардлагыг тодорхойлох

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны үндэс суурь нь тухайн тоног төхөөрөмжийг хариуцсан ажилладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчид байдаг ба Эрүүл мэндийн сайдын 2006 оны 439 дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникчдийн бүрэлдэхүүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” тушаалын дагуу Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй инженер, техникчдийн судалгаа хийсэн.

Нийт 15 эрүүл мэндийн байгууллагын 7 байгууллага нь (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ, ЦССҮТ) инженерийн техникийн албатай, 6 байгууллага нь (ЭСҮТ, СЭМҮТ, ГТ, АӨСҮТ, ХТС, НЭМҮТ) эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженергүй, 6 байгууллага (СЭМҮТ, ГТ, ЗӨСҮТ, АӨСҮТ, ХТС, НЭМҮТ) техникчгүйгээр эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа болон аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн актлах тоног төхөөрөмжийн мэдээллийг Хүснэгт 9-д үзүүлэв. Техникчийн тоонд хүчилтөрөгчийн болон гемодиализийн техникчийг оруулан тооцсон болно.

Хүснэгт 9. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчдийн хангалт

№	Байгууллагын нэр	Инженер, техникийн тасагтай эсэх	Инженерийн тоо	Техникчийн тоо	Нийт тоног төхөөрөмжийн тоо	Нэг инженер тоног төхөөрөмжийн онгодох тоон тоо
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Тийм	9	6	871	100
2	Хавдар судлалын үндэсний төв	Тийм	7	8	943	160
3	Эмгэг судлалын үндэсний төв	Үгүй	Байхгүй	1	25	25
4	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Үгүй	2	1	330	10-120
5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Үгүй	Байхгүй	Байхгүй	174	-
6	Геронтологийн үндэсний төв	Үгүй	Байхгүй	Байхгүй	26	26
7	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Тийм	5	1	1478	362
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Тийм	6	1	2420	484
9	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	Үгүй	1	Байхгүй	136	136
10	Халдварт өвчин судлалын үндэсний төв	Тийм	3	3	674	225
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	Үгүй	Байхгүй	Байхгүй	110	-
12	Хүүхдийн төв сувилал	Үгүй	Байхгүй	Байхгүй	124	-

13	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Тийм	3	1	480	100
14	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	Тийм	1	1	435	435
15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Үгүй	Байхгүй	Байхгүй	97	-
ДУНДАЖ			37		8149	220,2

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 439 дугаартай “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникчдийн бүрэлдэхүүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” тушаалын дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулж ажилладаг.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникчдыг хангалтын тухайн эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоотой харьцуулахад дунджаар нэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерт 220 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж ноогдож байгаа нь нэг инженерийн ачаалал өндөртэй ажиллаж байгааг илэрхийлж байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчдын цалингийн шатлалыг судлахад Инженер техникийн албаны дарга инженер ТҮ-7, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер ТҮ-6, техникч ТҮ-4, ТҮ-5 ангилалаар цалинждаг бөгөөд ажлын байрны тухайд хэвийн нөхцөлд ордог, зарим байгууллагын онцлогоос хамаарч онцгой нөхцлийн нэмэгдэл авдаг, илүү цагийн хөлс бусад нэмэгдэл шагнал урамшууллыг байгууллагын дотоод журмаар зохицуулагддаг байна. Хүчилтөрөгчийн техникийн хувьд ажлын байр нь хортой нөхцөлд хамаардаг.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн ажлын байрны нөхцөл байдлыг 9 асуумж бүхий судалгаагаар тодорхойлоход нийт 15 байгууллагаас 4 байгууллага нь (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ЗӨСҮТ, ЦССҮТ) эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний өрөөтэй боловч, зориулалтын бус шал, газардуулга байхгүй өрөөтэй байна. Мөн инженер техникчдыг сарын хэрэгцээний цахилгааны лент, тугалга зэргийг авагч, төрөл бүрийн хэмжээтэй эсэргүүцэл, конденсатор, транзистор, цавуу, цагираг, сойз, боолт, шруп зэрэг наад захын гар доорхи сэлбэг материалуудаар хангадаггүй байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн сургалтын хэрэгцээ шаардлага маш өндөр байгаа бөгөөд өнөөдрийн нөхцөл байдалд тухайн байгууллагад тоног төхөөрөмж нийлүүлж буй ханган нийлүүлэгч байгууллагын инженерүүд тухайн тоног төхөөрөмж дээрээ ашиглалтын болон аюулгүй ажиллагааны сургалт хийдэг. Засвар үйлчилгээний дэлгэрэнгүй сургалт явагддаггүй байна.

Сургалтын хэрэгцээ шаардлагын талаар 37 инженерээс 5 бүлэг сэдвээр тодорхойлоход эмнэлгийн тоног төхөөрөмжийн ангилал тус бүрийн засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагааны сургалт өөрөөр хэлбэл төрөлжсөн сургалт хамгийн их хувь буюу давхардсан тоогоор 103 санал авч нийт сургалтын хэрэгцээний 56%-ийг эзэлж байна. Энэхүү төрөлжсөн сургалтыг дотор нь яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, мэс заслын тоног төхөөрөмж, лабораторийн тоног төхөөрөмж гэх мэтчилэн 15 хэсэгт хуваан судалгаа авсан. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, худалдан авах үйл ажиллагааны талаар сургалтын тухайд хамгийн бага буюу 6,5%-ийг эзэлсэн байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн сургалтын хэрэгцээний талаарх мэдээллийг бүлэг болгон Хүснэгт 10-д үзүүлэв. Энэхүү тоо нь давхардсан тоогоор гарсан болно.

Хүснэгт 10. Сургалтын хэрэгцээ, шаардлага

№	Сургалтын чиглэл	Тоо	Хувь
1	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний менежмент, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	33	18.2
2	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, худалдан авах үйл ажиллагаа	12	6.5
3	СТ, MRI зэрэг нарийн нийлмэл тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаа	18	10
4	Мэргэжлийн гадаад /англи/ хэл	15	8.3
5	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ангилал тус бүрийн засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаа	103	56

Сургалтын хэрэгцээ шаардлага



Дүрслэл 3. Сургалтын хэрэгцээ шаардлага

ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/340 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 10 хоног ажиллаж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээ, тооцоо судалгаа хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн барилга байгууламж, дэд бүтцийн хувьд өөрийн гэсэн байргүй 2, ашиглагдаж буй байр нь ашиглах нөхцөл муудсан 5 эрүүл мэндийн байгууллага байна.

ЭМЯ-ны харьяа байгууллагын тухайд нийт 2790 нэр төрлийн (давхардсан тоогоор), 8640 ширхэг, **177,438.8 сая** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байна. Үүний 69,9 тэрбум төгрөгийн буюу 39,4% нь сүүлийн 2 жилд гадны хөнгөлгтэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хувийг тооцож үзэхэд 15 байгууллагын тухайд 73-100% буюу дундажаар **90,02%** -тай байна.

2017 оны хувьд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс 8 байгууллага 514 ширхэг **1,493.1 сая** төгрөгийн тоног төхөөрөмж актлаж, ашиглалтаас гаргахаар холбогдох байгууллагад хүсэлтээ өгсөн байна.

Хэдийгээр үндэсний төвүүдэд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн тоо өндөр байгаа боловч, технологийн хөгжлийн дагаад эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага байсаар байна. Судалгаанаас үзэхэд Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулахад нийт **23,4 тэрбум** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтын зардалд **121,4 сая төгрөг** шаардлагатай байна.

Илүүдэлтэй болон ашиглагдахгүй тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, шилжүүлэн боломжтой эсэхийг судлахад илүүдэлтэй тоног төхөөрөмж маш бага, 4 эрүүл мэндийн байгууллагад 6 нэр төрлийн тоног төхөөрөмж байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн гэмтэлтэй тоног төхөөрөмжийн судалгаа хийхэд нийт 105 нэр төрлийн 365 ширхэг тоног төхөөрөмж гэмтэлтэй бөгөөд засварлах шаардлагатай байгаа бөгөөд тэдгээрийг засварлахад **1,818.8 сая** төгрөг шаардлагатай байна.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад анхаарал хандуулахаас гадна чухал шаардлагатай зүйл бол тухайн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, шалгалт баталгаажуулалтад хамруулах, тухайн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний асуудалд анхаарал хандуулах нь зайлшгүй байгаа бөгөөд энэ чиглэлээр судалгаа тооцоолол хийхэд төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалтад **121,4 сая** төгрөг, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд **7,0 тэрбум** төгрөг шаардлагатай байна. Засвар үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийг ангилж үзвэл гэмтэлтэй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 1,8 тэрбум төгрөг, хугацаат сэлбэг хэрэгслийн зардалд 2,1 тэрбум төгрөг, өндөр өртөгт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд 3,1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна. Өндөр өртөгт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд MRI, CT, ангиографийн аппарат гэх мэт үйлдвэрлэгчийн баталгаат засвар үйлчилгээний алтан, мөнгөн гэрээг хамааруулан тооцлоо.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны үндэс суурь нь тухайн тоног төхөөрөмжийг хариуцсан ажилладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникийн ажилчид байдаг ба тэдгээрийн хангалт, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Нийт 15 эрүүл мэндийн байгууллагын 7 байгууллага нь (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ, ЦССҮТ) **инженерийн техникийн албатай**, 6 байгууллага нь (ЭСҮТ, СЭМҮТ, ГТ, АӨСҮТ, ХТС, НЭМҮТ) эмнэлгийн тоног төхөөрөмжийн **инженергүй**, 6 байгууллага (СЭМҮТ, ГТ, ЗӨСҮТ, АӨСҮТ, ХТС, НЭМҮТ) **техникчгүйгээр** эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа болон аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна. Инженерийн ажлын ачааллыг тухайн эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоотой харьцуулахад дундаар нэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерт 220 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж ноогдож байгаа нь нэг инженерийн ачаалал өндөртэй ажиллаж байгааг илэрхийлж байна.

Сургалтын хэрэгцээ шаардлагыг 5 бүлэг сэдвээр тодорхойлсон ба 56%-ийг эмнэлгийн тоног төхөөрөмжийн төрөлжсөн мэргэшүүлсэн сургалт зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

ЗӨВЛӨМЖ

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шат дараалалтай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
2. Эрүүл мэндийн байгууллагын төсөвт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шалгалт баталгаажуулалт, хугацаат сэлбэг хэрэгсэл, өндөр өртөгт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардлын төсвийн зардлын тусдаа зүйл анги болгон оруулах
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн төгсөлтийн дараах тасралтгүй сургалтын тогтолцоог сайжруулах, төрөлжсөн мэргэшүүлсэн инженер бэлтгэх
4. Шинэчлэгдсэн батлагдсан стандартын дагуу инженер техникчийн харьцааг хангах
5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн ачааллыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах, тухайлбал: CT, MRI гэх мэт нарийн нийлмэл бүтэцтэй тоног төхөөрөмжийг хариуцан ажилладаг тусдаа инженертэй болох, орон тоог баталгаажуулах